

УДК 94(517)

СУДАРЧ, САЙД ИНЖАННАШИЙН ОРЧУУЛГА “ХЭВ ДУНДЫН ЁСОН”-НЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ ЗУУР

Батсуурь А.

Ховд их сургууль. Хэл зохиолын тэнхимийн профессор, Ховд, Монгол Улс

E-mail: batcuury@gmail.ru

Товч хураангуй

Сударч В.Инжиннаши орчуулгын гол зорилго нь танин мэдэхүйн үндэс, хожим мэдлэгт тэмүүлэгчдэд зориулсан гарын авлага болгон өгөх явдал юм. Энэ болбоос Күнз хийгээд Күнзийн сурталтны сэтгэлгээ соёлын нэг гол цөм бөгөөд үүнийг “Хэв дундыг сахихуй ёсон” гэдэг. Күнзийн «төв дунд» гэсэн зөгнөл одоо «хэв» гэсэн ойлголттой нягт уялдаж байна.

Инжаннашийн уран зохиолын туршлагыг нарийвчлан судалж үзвэл энэ үзэл бодлыг үндэс болгон ашиглах нь зүйтэй юм. 23 бүлгээс бүрдсэн «Чжун-юн» («Дунд ба тогтмол байдал» эсвэл «Төв ба нийтлэг байдал») каноник трактат нь МЭӨ 5-р зууны Күнзийн нэрт гүн ухаантан Зи Си-тэй холбоотой юм. Түүнийг Күнзийн ач хүү гэж үздэг. Энэ бол «Ёслолын бүртгэл» (Ли Чи)-ээс бие даасан текст болгон тусгаарласан ёс зүйн шинж чанартай трактат юм. Энэхүү текст нь онтологийн асуудлуудад зориулагдсан болно: энэ нь чин сэтгэлийн хувийн амжилт ба хүрээлэн буй бодит байдлын дарааллын хоорондох харилцааны метафизикийн зарчмуудыг бий болгодог. Зөв замаас юу ч хазайхгүй байх нь «дунд», өөрчлөх зүйл бол «тогтвортой байдал» биш юм. Дунд ба тогтмол байдал нь сүр жавхлантай тул жирийн хүмүүст хүрч чаддаггүй. Юуны өмнө тэд ард түмэндээ тохиолдож буй бүх зүйлийн хариуцлагыг хүлээдэг захирагчтай холбоотой байдаг. Энэ нь Күнзийн сайн мэддэг зарчмыг «алтан дунд» гэж тайлбарладаг. Ёс суртахууны энэхүү зарчим юунаас бүрдэхийг зохиогч тодорхойлжээ. Хүмүүсийн харилцаанд «зохирол» гэхээс илүү чухал зүйл байдаггүй гэж Күнз номлосон. “Хэв дундын ёсон” номд “...ёслол журамд нийцэхүйг “зохирол” хэмээмэй. Дунд болбоос тэнгэрийн дор хэрэг үйлийн эх үндэс болой, зохирол болбоос тэнгэрийн дор түгээмэл жам болой. Дунд хийгээд зохирол дор хүрэхүйд тэнгэр газар тус тусын сууринаа тогтнож, түмэн бодос төлжин дэлгэрэх бөлгөө” хэмээсэн байдаг. Зохирол нийцэл бол бүх тохиолдолд дагаж мөрдөх ёстой бүх нийтийн зам юм. Энэ нь «алтан дунд» зарчмыг хэрэгжүүлэхийг урьдчилан таамаглаж байна.

Түлхүүр үг

Инжаннаши, хэв дундын ёс, орчуулга, үзэл танилт.

UDC 94(517)

THE TRANSLATION OF THE SCHOLAR AND MINISTER INJANNASHI IS ABOUT «HEV DUNDYN YOSUN»

Batsuuri A.

Ph.D (History),

Hovd university. Professor, Department of linguistics, Khovd, Mongolia

E-mail: batcypyp@gmail.ru

Annotation

The main purpose of the translation of the scholar V. Injinnashi is to provide the basis of cognition and later a guide for those who seek knowledge. This is the core of Confucianism, and it is called “rule of norm and middle”. Confucius’s prophecy of the “central average” is now closely aligned with the notion of the “norm”. The “central average” or “norm” should not be “overstated” or “understated” and should only be “adjusted”. A closer look at Injannashi’s literary experience suggests that this view should be used as a basis. The canonical treatise «Chzhun-yun» («Middle and constancy» or «Centrality and Commonality»), consisting of 23 chapters, is attributed to Zi Si, a famous Confucian philosopher of the 5th century BC. He is considered as the grandson of Confucius. This is a treatise of an ethical nature, separated into an independent text from the “Records of the Ritual” (Li Chi). This text is devoted to ontological issues: it establishes the metaphysical principles of the relationship between sincere personal success and the sequence of surrounding reality. Not deviating from the right path is “middle”, and what changes is not “stability, constancy”. Middle and constant are so majestic that they are inaccessible to the common man. First of all, they are associated with the ruler, who takes responsibility for everything that happens to his people. The author defines what this moral principle consists of. Confucius preached that there is nothing more important in human relationships than “harmony”. The middle ground is the root of action under heaven, and harmony is the common ground under heaven. When the middle and harmony are reached, the heavens and the earth will be established and the thoughts will flourish. Harmony represents universal path, which must be adhered to in all circumstances. This implies the realization of the principle of the “golden mean”.

Key words

Injannashi, hev dundyn yosun, translation, authentication.

УДИРТГАЛ

Сударч, сайд Инжаннаши олон хасаг тэрэг ном судрыг цөлмөн уншиж, эртний хэрэг явдлыг тэнхэрүүлэн судалж, өөрийн үзэл санааг боловсруулан бүхийдээ эрт өдгөөгийн мэргэдийн үзэл танилт, ухаарал сэхээрлээс эш үндэс авч, олон зүйлийн хэрэг учир, явдал мөрийг шинжин, ул суурьтайгаар өөрийн бүтээл туурвилд тусгах, хэт хойчийн ирээдүйд хэрэг болуужин хэмээн шигтгэл цохолт хийх нэгэн зүйлийн урлан бүтээх аргыг голлон хэрэглэж, жинхэнэ дорно дахины соёлт хүмүүний үлгэр жишээг үзүүлсэн их номын үйлчин сударч байсан ажгуу. Чингэхдээ олон хэлний судар шастирыг уншиж судлахын сацуу хожим хойчийн мэдлэг ухааралд дурлагчдын хэргийн учир зарим нэгэн сонгодог бүтээл, судрыг монгол хэлнээ орчуулан үлдээжээ. Үүний нэг нь эртнээс нааших олон үеийн мэргэдийн үзэл санааны хөтөч, хятадын утга соёл, иргэншилд гүн бат суусан Күнзийн сэтгэлгээ, үзэл санааы эх сурвалж болох “Таван ном¹, дөрвөн бичиг²” /五经四书五/ хэмээх цоморлогт багтах Күнз /孔子/-ийн ач хүү Зы Си /子思/-ийн туурвисан “Хэв дунд ёсон” /中庸/ хэмээх “бичиг” юм.

Юуны тул уг бичгийг орчуулах болсон түүний далд эчнээ санааг туурвил бүтээлээс нь тодруулан үзэж, ертөнцийн жам ёсны үзэгдэл – мөн чанар, хүмүүний сэтгэлийн эерэгүү хийгээд сөргүү сэтгэл хөдлөлийн учир гогцоог хэрхэн ухаарч байсан үзэл ухаарал, танин мэдэхүйн томьёоллыг бага боловч нээн үзүүштэй учир доор эш үндэс татан тайлбарлахыг хичээв.

Сударч Инжаннаши “Дунд хэв”³ нэртэй орчуулгын гар бичмэлийн төгсгөлийн цохолбор өгүүлэлд:

Бурхан бодьсугийн номыг уншваас буян садан дэлгэрээд

Богд мэргэдийн бичгийг боловсруулбаас бодис бүхнээ нэвтэрч /48/⁴

Дэлхий дахины тэргүүн нэгэн бэрх чухал дунд хэвийн судар төгсөв.

Буян эрдэмт их Чин улсын наймдугаар үеийн Эзэн хааны арван сүүдрийн хэр

Бүрэнт засагчийн дөрөвдүгээр он, цагаан сарын арван нэгэн сахигч нэрт эзний өдөр шөнө зулын доор, хулгана цагийн эхэнд бичиж төгсгөн, өдрийг тэмдэглэв.” хэмээн тэмдэглэснээр хөөн үзвэл Бүрэн засагч (同治) 1856 онд төрсөн бол “арван сүүдрийн хэр” гэвэл 1866 он, тэрээр 1862 онд хаан ширээнд суусан гэвэл “Бүрэнт засагчийн дөрөвдүгээр он” нь мөн 1866 он болж, дээр дурдсан хоёр тоон баримт яв цав тохирч буй тул уг дэвтрыг 1866 онд орчуулжээ. Чухам хэдэн сарын хэдний өдөр уг орчуулгаа дүүргэж цэг хатгаснаа “цагаан сарын арван нэгэн сахигч нэрт эзний өдөр шөнө зулын доор, хулгана цагийн эхэнд” гэж дурдсанаар хөөн гаргавал: Билгийн тооллын XIV жарны улаан бар жилийн есөн улаан мэргэтэй, огторгуй суудалтай хаврын тэргүүн сарын шинийн 11-ний өдрийн хулгана цагийн эхэн

¹Таван ном гэдэгт: “Шүлэглэлт ном” /诗书/, “Засагт ном” /尚书/, “Зурхайт ном” /易经/, “Ёслолт ном” /礼记/, “Хавар намар” /春秋/

²Дөрвөн бичиг гэдэгт: “Шүүмжлэлт өгүүлэл” /论语/, “Мэнз бичиг” /孟子/, “Их суртахуй” /大学/, “Хэв дундын ёсон” /中庸/

³Уг орчуулга нь одоо “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байна. /“Ёжит зохиол сул тэмдэглэл тууж” /Инжаннашийн бүрэн зохиол/ боть, 2010, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 0-р тал/

⁴“Монгол үсгийн дундад хэв” гар бичмэлийн нүүний дугаар

шөнө дүл, Аргын тооллын 1866 оны 02 сарын 25-ны өдөр ням гарагт шөнийн 23 цаг 40 минутын үед орчуулгаа төгсгөн, жаргаах цэгээ хатгаж ид 29 насандаа уг орчуулгыг хийснээ илтгэж, түүхэн чухал баримтыг үлдээжээ. Энд дурдсан цаг хугацааг нотолж бас “Инжиннаши би хорин ес насалтал” хэмээн төгсгөлийн цохолбор өгүүлэлдээ дурджээ.

“Бурхан бодьсадын номыг уншваас буян садан дэлгэрээд

Богд мэргэдийн бичгийг боловсруулбаас бодис бүхнээ нэвтэрч /48/

Дэлхий дахины тэргүүн нэгэн бэрх чухал дунд хэвийн судар төгсөв” гэж төгсгөлийн үгэнд санааны чанад, үзэл танилт нэгэнт тогсон болохоо Бурханы сургаал номлолын мөр зэргэмж болох гурван бодгалийн нэгэн даган замнагчийн ерөнхий нэрлэлт бодь хутгийн төлөөх дээд төрөлхтний¹ номыг судлан уншваас сайн үрийн чуулган буянт сэтгэлтэн, сансрын мунхаг харанхуйгаас гэтлэгчид олшрон дэлгэрэх хувьтайг зааж, ахиулан эртний мэргэдийн эергүү журамт ном бичгийг нягтлан судалж, **Буддын сургаал номлол – Күнзийн хэв журамтай** шүтэлцүүлэн боловсруулах бөгөөс сэрэхүйгээс тийн мэдэхүй хүртэлх таван цогц лугаа нэвтэрч, бэлгэ билгүүн дээшлэн сайжрах дундад үзэл², эергүү эвсэн амьдрахуйн хэв журамд нэврэхүйн үүд³ нь *“Дэлхий дахины тэргүүн нэгэн бэрх чухал дунд хэвийн судар”* хэмээн ухаарсны учир дор үүнийг орчуулсан болохоо тов тодорхой өгүүлжээ.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА

Сударч В. Инжиннажийн (Инжаннаши, 2010) үзэл нэгэнт тогссон тавин таван насандаа туурвисан “Үзэл санааг нь эс мэдэв” хэмээх шүүмжлэлт өгүүлэлд *“Нэгэн эрд гарсан хоёр эмийн тэмцэлдээн, нэгэн төрлийн баян ядуу хоёр гэрийн тэмцэлдээн, нэгэн хошууны албаны түшмэс шуувингийн⁴ тэмцэлдээн, нэгэн төрийн зальхай ба чигчийн⁵ эдгээр зэргийн олон зүйлийн тэмцэлдээнд цөмөөр тэмцэлдэхийн шалтгаан барилдлага нүдний өмнө машид ил байх үйл тул үүнийг үүрд байх нэгэнт тогтсон тэмцэлдээн”* хэмээн хувь бодгаль талаас нь үзвэл эсрэг тэсрэг атлаа тэмцэлдэх сэтгэлийн уг үндэс нэгэн ижил болохыг дүгнэж, бас санаа сэдэл, үйлс зорилго нь нэгэн чигтэй атлаа, бие биедээ мөчөөрхөх *“нэгэн ижлийн*

¹Гурван бодгаль: 1. Шравак (мо: сонссоноо дуурсгагч, тө: ལྷ་མཁའ་པུ་ཅལ་: śrāvaka,) гурван хөлгөний нэг шравакийн хөлгөнд орсон бодгаль. Их хөлгөний аймаг савыг өөрөө анхааран үл авсан бөгөөд бурхан тэргүүтнээс ном сонссоны учир сонсогч буюу шравак хэмээсэн буй. Сонссоноо бусдад дуурсгах учраас сонссоноо дуурсгагч ч хэмээмүй [БШСТТ. I-1999: 501]. 2. Брадигабуда (мо: өөрөө гэгээрсэн, тө: ར་པའི་ཆེན་པོ་: pratyekabuddha) Брадигабуда нь өөрөө ганцаар оршихуйд баясах бөгөөд эцсийн цагт бусдын увдист үл дулдуйдан өөрийн бодийг илт болгох бөгөөд нисваанисаас ялж үйлдэх тул тийн нэрлэмүй. Брадигабуда хирсийн эвэр мэт бөгөөд чухал явагч их, өчүүхэн хоёр бөгөөд гурав болой [БШСТТ. I-1999: 150]. 3. Бодьсадва (мо: бодь баатар сэтгэлт, тө: བློ་ཚལ་ལྷན་པོ་: bodhisattvāḥ) Их хөлгөний суралцах мөрийн бодгаль бөгөөд их бодийг олохын тул галавын өнө, газрын холыг үл ажран, тэргүүн ба үе гишүүний өглөг өгөхөд сэтгэл үл мятрах учир бодьсадва бодь баатар сэтгэлт хэмээжээ [БШСТТ. I-1999: 146].

²Буддизмын сонгодог гүн ухааны гол чиглэл болох дундад үзэл (мадхьямака)-ийн хоосон чанарын онолоор тайлбарлагдана. Аливаа юмс үзэгдлийг ганц зогсонго талаас биш мөн ганц хөдлөнгө талаас нь бус зогсонго хөдлөнгө хоёрын талаас нь бүхэл болгон таних буддын гүн ухааны үндсэн тогтсон таалын нэг нь төв үзэл буюу дунда үзэл юм.

³Күнзийн сэтгэлгээний өв цоморлог бүтээлүүд.

⁴Аливаа яамны бичээч: түшмэл шуувин [хоршоо] (төрийн яамны албан хаагч).

⁵Шударга, үнэнч.

урчуудын атгаг, нэгэн хөөлгөний отоочны атгаг, нэгэн номын гүрэмчийн атгаг, нэгэн ертөнцийн сургаалтны атгаг” гэх мэтийн алдас унал нь адил болохыг эчнээ тоочин дурдаж, чухамхүү эдгээр нь өмнө дурдсан тэмцэлдээний шалтгаантай хамт бүрэлдэх ажээ гэх үзэл танилтад хүрснээ “атгаг эдгээрүүд хэмээгч тэмцлийн орчлонтой хамт барилдан бүтсэн нэгэнт тогтсон энгийн зан” юм гэж томьёолжээ. Энэхүү томьёоллыг Инжаннашийн нанхиад хэлнээс орчуулсан Күнзийн ач хүү Зы Си-ийн (Зы Си, 2013) туурвисан “Хэв дунд”¹-аас эшлэн тодруулбал: “Хэлбэрэх үгүй нь дунд хэмээхүй. Үл халахыг нь хэв хэмээмүй. Дунд хэмээгч дэлхий дахины төв ёсон. Хэв хэмээгч тэнгэрийн доорхны тогтсон зүй”² гэж аливаа зүйлсийг ийм тийм хэмээн хоёр хязгаарт хэтийдүүлэлгүйгээр үүсэл үүтгэлийн үнэн мөн, төрөлх чанарт нь дулдуйдан танин барихыг “төв ёсон”, хэзээ ч осолдон хазайлгаж үл болох, атгаг, тэмцэлдээний бай, аль эсвэл халхавч бамбай үл болгох тийм чигч, хэзээ ч үл хэлбийлгэх тогтсон жам, зан журмыг “тогтсон зүй” хэмээн Инжаннаши ухааран ойлгож байсны гэрч бол түүний дээрх томьёолол юм (Сумадирадна, 1959; Жүгдэр, 1978; БШСТТ I-1999; Жалгаа, 2010).

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Чухамхүү санаа, агуулга бүхий томьёолол буддын судар шастирт тохиолдох үндсэн үзэл ойлголтын нэг юм. Үүнийг дэлгэрүүлэхийн тулд буддын гүн ухааны ойлголт ухагдахуунд түшин ярья.

“Тэр үзэгдэл өөрөө огоот эс бүтсний тул болой. Атгаг төдий нь үзэгдлийг эндүүрэхийн төдийд буйн тул болой” (Васубанду: 28a-28b) хэмээсэн эртний энэтхэгийн их сэтгэгч Васубандугийн үзэл нь аливаа юмс үзэгдлийн гадаад илрэл болсон шинж чанар нь тухайн зүйлийн дотоод мөн чанарыг илэрхийлэгч болж чадахгүй гэдэг үндэслэлийг гарган тавьж, тэр нь зөвхөн үзэгдлийн төдийд оршин танин мэдэхүйд зөвхөн янагуух үнэний харьцаанд оршигч юм гэж тодорхойлжээ (Batsuuri, 2011: 67). Чухамдаа тэрхүү муу сэтгэл, зүй бус ааш араншингийн мөнхүү чанар нь үзэгдэх өнгөндөө бус хүмүүний [сансрын] үйл, нисваанисаас үүдэгдэх нэг л уг үндэстэй болохыг өөрөөр хэлбэл бие-сэтгэлийн нэгдэл болох хүн буюу бодгалийг³ үйл нисваанисын эрхээр төрөгдөх “буян нүглийн авьяасаар үндэс нь дүүрээд түүн лүгээ даган зохилдсон амьтны төрлийг аваад эзлэн үйлдэх тул дүүрэн цувралт хэмээгдүй” (Сумадирадна, 1959: 265) хэмээн тодорхойлсноос тодорхой харж болно. Энэхүү үзэл ойлголтын суурь дээр уг “**Үзэл санааг нь эс мэдэв**” хэмээх шүүмжлэлт өгүүллийн үндсэн агуулгыг тавьж үзвэл “тэмцэлдээн”, “атгаг” хоёулаа үзэгдэх өнгө нь өөр өөр боловч үүдэх эх үүсвэрийн хувьд гагцхүү “орчлонтой хамт барилдан бүтсэн нэгэнт тогтсон энгийн зан” гэж “Хэв дунд”-д томьёолсныг богд

¹Энэхүү орчуулга нь “Монгол үсгийн дунд хэв” нэртэйгээр “Ёжит зохиол сул тэмдэглэл тууж” /Инжаннашийн бүрэн зохиол/ ботид Монгол бичгийн нийт 57 нүүр бүхий эхийг гэрэл зургаар оруулжээ. 260-316-р тал, Зы Си-ийн уг бүтээлийг М.Чимэдцэеэ 2013 онд, Ш.Эгшиг 2012 онд тус тус хятад хэлнээс орчуулан “Хэв дундын ёсон” нэртэйгээр хэвлүүлжээ.

²“Монгол үсгийн дунд хэв” “Ёжит зохиол сул тэмдэглэл тууж” /Инжаннашийн бүрэн зохиол/ Хөх хот, 2010, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 260-р тал

Жич: Үүнийг М.Чимэдцэеэ “Эс хазайхуй, эс хэлбийхүйг “дунд” хэмээмой, эс хувирахуй, эс өөрчлөгдөхүйг “хэв” хэмээмой. “Дунд” хэмээхүй нь тэнгэрийн дор төв ёсон, хэв хэмээхүй нь тэнгэрийн дор тогтоосон жам болой” хэмээн орчуулжээ. Зы Си, “Хэв дундын ёсон”, УБ., 2013, 28-р тал

³Мо: дүүрэн цувралт, Тө: ᠮᠣᠨᠭᠣᠯ

Зонхов “Бодь мөрийн зэрэг”-тээ “Анхан нь орчлон бүтэхийн шалтгаанд үйл хийгээд нисваанис хоёр хэрэгтэй боловч, нисваанис эрхэм мөн бөлгөө. Нисваанис үгүй бөгөөс хураасан үйл тооноос нөгчсөн буй боловч чийг хийгээд шороо тэргүүтэн үгүй хөрөнгөөр ногоо үл бүтэхчилэн үйлд хамт нэгэн үйлдэх нөхцөл үгүйн тул зовлонгийн ногоо үл бүтэхийн тул хийгээд нисваанис буй бөгөөс үйл урьд хураасан үгүй боловч тэр даруй шинэ хурааж, хойт цогцыг авахын тул болой” (Зонхов: 121а) хэмээн өгүүлсэнтэй жишин адилтгаж үзвэл тун тодорхой харагдана.

Сударч Инжаннашийн “Бурхан бодьсадын ном”, “Богд мэргэдийн бичиг” хоёрын гүн утга, эчнээ санааг зэрэгцүүлэн үзэхдээ хэрхэн ухаарч, яахин таньсан барьж буйгаа тодорхой өгүүлжээ.

Үүнийг эш татан үзье. Инжаннаши би, өчүүхэн мэдлэгээр орлонгийн үйл мөрийг өдөр шөнө, жил сарыг мэдэлгүй бясалган бодож, эцэст нь “*мөнхүү¹ үг үгүй, үнэр үгүй, дуун үгүй, дүрс үгүйд хүрч зогсжээ*” хэмээн хоосон чанарыг таних, бодьсадын мэдлэгт очин хүрэх ажээ хэмээн таньсан болохоо дурдсан байна. Тэгэл хоосон чанар гэгч нь чухам юуг өгүүлж, тэр танин мэдэхүйн үндэс яагаад болдгийн учрыг тодруулбал Инжаннашийн юунд хүрээд зогссоныг хэлээд өгнө.

Өнөөгийн шинжлэх ухааны хандлага нь судлах зүйлийг нэгдмэл байр сууринаас авч үзэж, асуудлын мөн чанарыг хэт явцууруулан ямар нэгэн зүйлд нялзаахаас аль болох зайлсхийх болжээ. Тиймээс бид асуудлыг аль болох олон талаас нь нэгдмэл байдлаар авч үзэж, аливаа зүйлийн мөн чанарыг ерөнхийд нь илэрхийлж чадах нийтлэг дүгнэлт гаргах нөхцөл болсон “үл хувьсах чанар” (инвариантность)²-ыг Буддын ёсоор бол *хоосон чанар*³-ыг тогтоох шаардлагатай. Иймээс Буддын гүн ухааны шүтэн барилдлага, арга билиг, хоосон чанарын ёсоор шүтэлцүүлэн аливаа асуудлыг нэгдмэл байр сууринаас авч үздэг аргазүйг баримтлах нь зайлшгүй. Энэ нь нэг ёсондоо орчин үеийн шинжлэх ухааны голлох судалгааны аргазүй болох ерөнхий тогтолцооны аргазүйтэй нэлээд ойролцоо аргазүйн тогтолцоо гэж үзэж болно. Юуны түрүүн Буддын үндсэн дөрвөн *тогтсон таалал*⁴-ын танин мэдэхүйн оногдохуун болох “суурь”-ийг томъёолон үзэх мэдэгдэхүүний нэгдсэн тогтолцоог тодорхойлон гаргаж, түүнд сэтгэл оюун, ухамсартай холбоотой элементүүд нь ямар үүрэгтэй болохыг тогтооно гэсэн хэрэг.

Сударч Инжаннашицаашлавшруулан: “*Юунхэмээвээс, эртний богд төрөлхтөн сургаалийг үлдээсэн нь хойч үеийн хүмүүн төрөлхтөнийг богд болгохуйн үүд онолт бөгөөтөл*” хэмээн бодь мөрийн зэргээр замнан, үйл нясваанисаас хагацан, нирваан сэтгэлд хүрэх үрийн төлөөх сургаал номлол гэж таньсанаа тодорхой өгүүлж, зарим

¹Мөнхүү хэмээх нь мөн чанар, тэрхүү чанар, хоосон чанар гэдэгтэй нэгэн утгатай үг.

²Аливаа шинжлэх ухааны гол асуудал бол үл хувьсагч чанар (инвариантность) юм. Шинжлэх ухааны аль нэгэн салбарт гарч байгаа дэвшил нь үл хувьсагчийн холбооны талаар бидний мэдлэг гүнзгийрч байгаатай шууд холбоотой гэж батлан хэлж болно хэмээн эрдэмтэд үздэг.

³са.: śūnyatāh, тө.: སྤྲུལ་ཅིན་ Гүн ухаантан Агваанбалдан “Нөхцөл шалтгаанд дулдуйдан бүтсэн аливаа бүхэн нь өөрийн мөн чанараар хоосон хэмээн номлосон, үүнээс гайхамшиг болох сайн номлол хаа байх вэ?” [Агваанбалдан. Шүтэн барилдахуйн магтаал./rten ‘brel bstod pa’i grel/ 36b], [Жүгдэр Ч. Агваанбалдангийн гүн ухааны үзэл, УБ., 1978, 57-р тал] гэж тодорхойлсон байдаг.

⁴са.: siddhānta, тө.: བཤམ་པ་ нь шүтээн, мөр, үр гурав ба үзэл, бясалгал, явдал гурвын ялгалыг шинжлээд, өөрийн оюуны илдраа магад энэ болой хэмээн шийтгэсэн туйлын хувь үүнийг өгүүлэх бөгөөд түүнийг үзүүлэхээр өгүүлэгч үгсэд ч тогтсон таалал хэмээн нэрийдсэн буй болой. [БШСТТ. II-1999:282]

үес энэ сургаалыг өөрийн атгаг санаанд уяж “эдүгээх цагт нэгэн зүйлийн буянт төрөлхтөн хэмээн гарч, үе үеийн улс төрд түрэмгий завшааныг эрхлэн шахагджээ” гэж сургаалын үндсэн чанагуух зорилгыг нь завсар зуурын ашиг завшаан болгож, эрх ашгийн бамбай болгож буйг ч шүүмжилжээ. Бодь мөрийн сургаал номлол нь чухам ямар ойлголт ухагдахуунд суурилан хөгжиж ирснийг товч төдий тодруулан үзвэл Инжаннашийн санаа онолт улам илэрхий болно.

Дарма хэмээх ойлголт нь аливаа оршихуйн үүтгэл санааг танин мэдэх бололцоо (ахуйлаг хийгээд санаалаг ойлголт¹)-ных нь хамт томьёолон үзэх авидармын ёсон дахь хамгийн гол үндсэн ойлголт мөн бөгөөд чухам л эндээс хүний сэтгэл, сэтгэцийн аливаа үйл үйлдэл, үр дүн (амгалан хийгээд зовлон, зовлон ч бус амгалан ч бус)-г ухааран сэрж, өөрийн сэтгэлийн дотоод үндэс дэх нисваанис хэмээн нэрлэгдэх, өрнийн судлаачдын клеша хэмээн санскритаар нэрлэн зүй бус ёс суртахууны элементүүд гэж ойлгох сэтгэлийн сөрөг нөлөөлөл буюу эрчмийг хаан, түүнийг боомтлох ерөндөгийг улам боловсронгуй болгох явцад хүмүүний бие хэл сэтгэлийн үйл, үйлдвэрийг сайн зүгт залан жолоодох арга зам (мөр)²-ыг үндэслэн бий болгоод, эцсийн зорилго болох нирваан хэмээх сэтгэлийн эерэг төлөв байдал буюу гэгээрэл (үр)³-ийг олох нэг ёсондоо сэтгэлээ таньсан хүн (бодьсатва)⁴-ий өөрийгөө танин мэдэхүйн онолын төвшинд хүртэл авидармын ёс⁵ хөгжихдөө Бурхан багшийн номлосон анхдугаар номын хүрднээс эш үндэс авсаар гуравдугаар номын хүрдэнд дээд авидарма хэмээн нэрлэгдэх хүртлээ алгуур аажим төгөлдөржсөөр иржээ. Чухамхүү энд л Буддын сэтгэл судлал буюу сэтгэлийн тухай сургаалын хамаг охь шим нь оршин буй болно.

Инжаннашийн дээрх үзэл онолт нас ахихад хэрхэн лавшран тогтсоныг түүний бүтээл туурвилаас эш татан өгүүснээс харж болно. Цаанаа “зэвүүрхэн жигших нууц атгаг сэтгэл” өвөрлөөд, наанаа “нүүрийн дээр инээн нийлүүлэн үзэх” атлаа яаж тийн авирлаж, хуурмаг сэтгэл гаргаж чаддагийг “цүлис би хажуунаас харсаар” мэдэрч “маш олноос олонтоо үзсээр сая ийм нэгэн зүйлийн хилэнцэт хорхой мэт хүн хэтэрхий олонтоо байхыг лав цав олж мэдээд өөрийн зантайгаа таацуулан үзвэл аяа үнэхээр тэнгэр газар алслан, галав дэлхий өөрчлөгджээ” хэмээн өөнөө энэ цаг юутай цөвүүн болсныг үзэж, “Авай эдгээр зэргийн атгаг харанхуйн агаар амьсгалын дотроос зангидаж бүтсэн хүн хэмээгчид эгнэгт энгийнээсээ этгээдхэн олноосоо онцгойхон хэмээн явах ардын дотроос гарах буй еэ” хэмээн хүн ардын оюун санаа улам улмаар харанхуй болж буйн шалтгаан нь, “төрөлх тув тунгалаг” гэгээн сэтгэл ямх ямхаар бус алд алдаар бүүдийн байгааг олж хараад хэрхэх учраа олохгүй бачууран байгаагаа Инжаннаши “Үзэл санааг нь эс мэдэв” хэмээн өөрийнхөө сэтгэл санаагаа нээж, “Аяа үүгээр үзвэл, этгээд үзэлтэн нэгэнт эеэргүү гэгээнд үл хүрэхийг мэдэвч этгээд таны үзэл саналыг нь эс мэдэв. Эрхбиш лав нэгэн зүйлийн эрхлэн баримтласан онол санал буй болой. Нарийвчлан асуухуйяа бэрхтэй” үүний учрыг олж, хужрыг тунгаахыг хожмын мэргэдэд захин үлдээсэн ажээ.

Тэрээр “Богд мэргэдийн бичиг” нь “долоон жил эс хоригдсон аваас”, “тэр мэт самуун цагт эс тохиолдсон бөгөөс”, “хотод эс хоносон болвоос”, “бусдын бурууд”,

¹мо.: суурь, са.: nidana тө.:གཞི

²са.: marga, тө.: ལམ

³са.: phala, тө.: འབྲས་བླ

⁴са.: bodhisattva, тө.: བླ་ཆུབ་སེམས་དབང

⁵са.: siddhanta, тогтсон таалал, тө.: བླ་མཐུན

“өөрийн үнэнчид”, “цагийн самуунд” гэх мэт завшаант явдал хэрэг тулгарсны хувиар Күнз зэрэгцсэн “Таван ном, дөрвөн бичиг” хэрхэн ямар саад савчидтай тулгарч, уламжлан өнөө хүрч ирсэнийг тодотгоод, Энэ гурван богд сая өөр бусад цаг энэ гурван гэгийг эрдэмт улируулан хэрэглэжээ” хэмээн дурджээ.

“Илэрхий гэрч баримтат, богдын бичгийн туйлд хүрвээс ярагтаахоосон чанарын бурханы номын ухааныг түшиглэмүй, эдүгээгийн мэргэд өөрийн тусыг олохуйдаан үл хичээн бүгд бурханы тусыг олохыг хичээмүй. Энэ мөн, хоосны гаднах хоосон чанар бус уу? хэмээн бид хоёул нэгэн зэрэг элэг хөштөл инээлдсэн бөлгөө” хэмээн “Бурхан бодьсадын ном”, “Богд мэргэдийн бичиг” хоёрыг зэрэгцүүлэн, үзэл онолтыг нь шүтэлцүүлэн явах байтал үзтэл гаднах атгаг үзэгдэлд төөрөгдөн номын мөн чанарын ухааныг үл олох бус уу? гэж ёсжлол идээмийн үймээнийг үүсгэсэн ажээ.

ҮР ДҮН

Сударч Инжаннаши “миний энэхүү “дунд хэв”-ийн онолт нь чанараар эхлэн хоосноор төгссөн нь ил элэсоор удирласан болгон битүү эрдэмд хүрүүлэх арга шалтгаан мэт, богдын дүрмийг гадна илтгээд бурханы онолтыг дотроо агуулжээ” хэмээн “Хэвийн дундын ёсон”-ны мөнхүү гүн учир нь аливаа юмсыг бараглах “чанараар эхлэн” барьж, чанад оршихуйг “хоосноор төгссөн”-өөр танин ухаарч, инад – чинад чанаруудыг харилцан шүтэлцээнд таних эрдмийн суурь нь “богдын дүрмийг гадна илтгээд бурханы онолтыг дотроо агуулжээ” гэж дүгнэсэн хэрэг юм.

Инжаннашийн бодол санаанд нэгэн сэжиг, түүний шалтаан чухам юунд буйг “бидний монголын шүтээн барилдлага ба шударгын буян нь хэдий зүйтэй мэт боловч, эдийн хишиг хийгээд ухааны хувь даан ч нимгэн, адагтаан ил гэгээн, тус гавьяат, соёлын ухаан үл төрөгдөх атал эчнээ нууц хоосон чанарт номын санваар хэрхэн дэлгэрсэн болов” хэмээн бодолхийлэн ийм сайхан буян шударгын үйлийг хийх нь зүйн хэрэг боловч хураасан нь бага, ухаарсан нь өчүүхэн тул тус эрдэм, соёл гэгээрэлгүй байтал юунд буддын санваар, шагшаавад дэлгэрэх нь юу вэ гэж халаглан өгүүлжээ. Үүний учир шалтгааныг тэрээр байгаль, орчин, улирал мөчийн аливаа үзэгдэл зүй зохисоороо тохиохгүй учир хүн ард нь зориг зүрхгүй авч хий хуудам мэдэлтэй боловч, онцгойрон мэргэжих нь цөөн байх гэж учирлаад “Олонх нь судар шинжвээс шарын шашны түйтгэр болмуй, бэхэс амталваас бичгийн хаалганы хулгай болмуй” хэмээн мунхаран бодолхийлэх учир “Үүний дундаас гэнэт, өдрийн одон, шөнийн солонго мэт нэгжгээд хошоод цолгорсон мэдэл ухаантан гарваас, од эсвээс эд чухаг, эсвээс эрх дутуу, эрхбиш нэгэн зүйлээр түүний хүчнийг бууруулж, цолгорон нэвтрэхэд хүрэх үгүй” гэж ёжлон өгүүлжээ.

Эцэст нь “Бурханы номонд үйлийн эрх хэмээмүй. Богдын бичигт тэнгэрийн төрөлх хэмээмүй” хэмээн уг хоёр номлол сургаалын танин мэдэхүй суурь өөр өөр боловч “уг мөн чанарын онолт нь нэгэн адил” гээд Бурханы номд “цөмөөр өнгө үгүй, үнэр үгүй, дуун үгүй, бод үгүй хоосон агаараар өөрийн хувьдаа ирж очихыг адилтган үлгэрлэн өгүүлсэн буюу”. Харин Богдын бичиг нь “Тэнгэрийн төрүүлсэн хэмээгч Хурмаст тэнгэр түүнийг албадаж илгээснийг өгүүлсэн бус, бичгийн ёсонд илбэ ил гэрч, тодорхой тэмдэг үгүйг өгүүлэх үгүй тул, арга үгүй Хөх тэнгэр, гурван гэрэл, аянга, гилбэлгээнийг барьж, нийтээр итгэмжлүүлж, сайнд удирдах сэдлээр буюу” гэж танин мэдэх зам мөр нь өөр өөр болохыг тодорхойлжээ.

Инжаннаши уг төгсгөлийн цохолбор өгүүллээ “Богд Зы Си үйлийн эрхийг эс мэдсэн бус, бусдын эс мэдэхийг мэдэж тэнгэр хэмээсэн болой, Мэргэд бээр хянан шинжлэх ажаму” хэмээн “Хэв дундын ёсон”-ыг зохиогч Богд Зы Си бээр хамгийг мэдсэний үр шим аливаа зүйлс цөм шүтэн барилдах жам ёсыг дундад үзлээр танин мэдэх бололцоотой гэж үзсэнийг хожмын мэргэд шинжин судлахыг захиж, энэхүү өгүүлэлдээ цэг хатгажээ.

ДҮГНЭЛТ

• Сударч, сайд В. Инжиннашийн “Хэв дундын ёсон”-ыг орчуулсан гол зорилго нь аливаа зүйлийг танин мэдэхүйн суурь, хожим хойчийн эрдэм мэдлэгт тэмүүлэгчийн гарын авлагад өргөхийн учир ажээ.

• Орчуулгын хэл найруулга уламжлалт монгол бичгийн хэлний урсам найруулгаар бодит ойлголт ухагдахууныг оновчтой оноон нэр хадаж орчуулсан нь илт харагдана.

• В.Инжаннашийн ертөнцийг үзэх үзэл, баримталж ирсэн үзэл танилт нь бүр залуу насанд нь хэвшин тогтсон болохоо орчуулгын төгсгөлийн цохолбор өгүүлэлд бүрнээ илэрхийлж, хожим хойчийн уран бүтээл, туувилдаа баримталсаар ирснийг нас хэвийсэн үед туурвисан “Үзэл санааг нь эс мэдэв” хэмээх ёжит өгүүллээр нь хөөн үзэхэд тодорхой харагдана.

• “Бурхан бодьсадын ном”, “Богд мэргэдийн бичиг” хоёрыг энэ тэнцүү судалж, нэгийг нь өрөөсгөлдүүлэн хэтийдүүлэх бус шүтэн барилдуулж ухаарч байсан нь түүний үзэл танилтын эх суурь болж байжээ.

• Сударч, сайд В. Инжаннашийн урлан бүтээх туурвил зүйн туршлагыг нарийвчлан судлахдаа энэхүү үзэл танилтаар дэвсгэр хийвэл зохилтой мэт.

Ном зүй

Агваанбалдан. *Шүтэн барилдахуйн магтаал* /rten ‘brel bstod pa’i gre/ 36b.

Батсуурь, А. (2011). *Буддын гүн ухааны авидармын ёсонд сэтгэцийн үзэгдлийг тайлбарласан нь /диссертаци/*. УБ., 67-р тал.

Буддын шашин соёлын тайлбар толь, Буддын судлал (1999). Цуврал-II, Нэг, хоёрдугаар дэвтэр. УБ /зохиогчид: Ш. Чоймаа, Л. Тэрбиш, Д. Бүрнээ, Л. Чулуунбаатар/.

Васубанду. *Dharmadharmaṭavibhaṅgavṛtti*, Ном хийгээд номын чанарыг тийн ялгахуй, 28a-28b нүүр.

Жалгаа, Б. (2010). *Инжаннашийн оны бичиг*. УБ., 198-199-р тал.

Жүгдэр, Ч. (1978). *Агваанбалдангийн гүн ухааны үзэл*, УБ., , 57-р тал.

Зонхов. *Их бодь мөрийн зэрэг* /Byang chub lam rim chen po/ 121a.

Зы Си (2013). *Хэв дундын ёсон / орчуулсан М. Чимэдцэеэ*. УБ., 28-р тал.

Инжаннаши, В. (2010) *Ёжит зохиол сул тэмдэглэл тууж /Инжаннашийн бүрэн зохиол/*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

Сумадирадна (1959). *Төвөд монголын дохионы бичиг нэр үг утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч* зул, I-II боть, УБ. 265-р нүүр.

References

- Agvaanbaldan. *Praise of idolatry* / rten 'brel bstod pa'i grel / 36b.
- Batsuuri, A. (2011). *Explanation of mental phenomena in the avidarmic practice of Buddhist philosophy* (dissertation). UB., 67.
- Dictionary of Buddhism and Culture, Buddhist Studies* (1999). Series-II, Books One and Two. UB / authors: Sh. Чоймаа, Л. Terbish, D. Burnee, L. Chuluunbaatar/.
- Vasubandu. *Dharmadharmatavibhangavrtti, Thus the Distinction between Book and Book Quality*, 28a-28b.
- Zhalgaa, B. (2010). *Injannashi's letter*. UB., 198-199.
- Jugder, Ch. (1978). *Agvaanbaldan's philosophical views*. Ulaanbaatar, 57.
- Tsonkhov. *The degree of the Great Bodhi Line* / Byang chub lam rim chen po/ 121a.
- Zy Si (2013). *Moderation* / translated by M. Chimedtsee. UB., Page 28.
- Инжаннаши, В. (2010) *Yojit's novel is a weak note* / Injannashi's complete novel/. Inner Mongolia People's Press Committee.
- Sumadiradna (1959). *Tibetan-Mongolian Sign Language, Nouns, Senses, Darkness Eraser*, Volumes I-II, UB. 265.

ХАВСРАЛТ¹

Бурхан бодьсадын номыг уншваас буян садан дэлгэрээд
 Богд мэргэдийн бичгийг боловсруулбаас бодис бүхнээ нэвтэрч /48/
 Дэлхий дахины тэргүүн нэгэн бэрх чухал дунд хэвийн судар төгсөв.
 Буян эрдэмт их Чин улсын наймдугаар үеийн
 Эзэн хааны арван сүүдрийн хэр
 Бүрэлт засагчийн дөрөвдүгээр он
 Цагаан сарын арван нэгэн сахигч нэрт эзний өдөр шөнө зулын доор
 Хулгана цагийн эхэнд бичиж төгсгөн, өдрийг тэмдэглэв.

Инжаннаши би, миний бармагийн тоосны төдий мэдлээр агуу огторгуй мэт орчлонгийн үйлийг хянаваас, өдөр шөнө үргэлжлэн, жил сар золголдон үг үгүй, дуу үгүй, тэргүүнгүдэйн эргэцүүлэн тойруулан бодсоор, эцэст /49/ мөнхүү үг үгүй, үнэр үгүй, дуун үгүй, дүрс үгүйд хүрч зогсжээ. Юун хэмээвээс, эртний богд төрөлхтөн сургаалийг үлдээсэн нь хойч үеийн хүмүүн төрөлхтөнийг богд болгохуйн үүд онолт бөгөөтөл, эдүгээх цагт нэгэн зүйлийн буянт төрөлхтөн хэмээн гарч, үе үеийн улс төрд түрэмгий завшааныг эрхлэн шахагджээ. Ер Вэн, Ү хоёр вангийн мэт эзэн ба Жэү, Шоо хоёр гүнгийн адил сайд үл гарах нь юуны шалтгааныг эс олж мэдсэнээр дув дуугай, сэв сэмээр болохоос өөр юуныг сэтгэх, тиймийн тул илт туулсан Шагжамүни бурхан ийм ардад сэнхрэл болгон, дээд хоосны хаалганд дэвшүүлэх замыг нээн гаргасан ч буй еэ. /50/ Инжиннаши би хорин ес насалтал, намайг мэдэж чадсан нэгээхэн нөхөр, Шоо Хү, Жиян Шэн-гийн өгүүлсэн нь: “Улаан тоосны бид бээр, ном бичиг хоёроос бус зүйлийг хэлэлцвээс эсвээс биеэ магтмуй, эсвээс бусдыг

¹“Монгол үсгийн дунд хэв” “Ёжит зохиол сул тэмдэглэл тууж” /Инжаннашийн бүрэн зохиол/ Хөх хот, 2010, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо 307-335-р тал.

буруушаамуй, эсвээс цагийг муушаамуй, энэ гурваас үл гармуй. Эрт, Вэн ван, Иү Ли хотод долоон жил эс хоригдсон аваас, “Еи Жинг ном” /“Зурхайт ном” 易经 yì jīng /-ыг хэн ялган гаргамуй. Пү Си, тэр мэт самуун цагт эс тохиолдсон бөгөөс “Цүн Чиү бичиг”-ийг /“Хавар намар” 春秋 chūnqiū / хэн үүдэн чадамуй? Еэ Гүн, Цоо Хэхотод эс хоносон болвоос, “Заү Ли судар” /“Ёслолт ном” 礼记 lǐ jì /-ыг хэрхэн нэгтгэмүй. Вэн ван бусдын бурууд “Зурхай”-г ялган чадав, Жэү гүн /51/ өөрийн үнэнчид “Ёслол”-ыг хоцруулан чадав, Пү Си, цагийн самуунд “Засаг”-ийг тодорхойлон чадав. Энэ гурван богд сая өөр бусад цаг энэ гурван гэмийг эрдэмт улируулан хэрэглэжээ. Илэрхий гэрч баримтат, богдын бичгийн туйлд хүрвээс ярагтаахоосон чанарын бурханы номын ухааныг түшиглэмүй, эдүгээгийн мэргэд өөрийн тусыг олохуйдаан үл хичээн бүгд бурханы тусыг олохыг хичээмүй. Энэ мөн, хоосны гаднах хоосон чанар бусуу? хэмээн бид хоёул нэгэн зэрэг элэг хөштөл инээлдсэн бөлгөө. Түүнчлэн, Инжаннаши би хэдүйбээр энэхүү “Дөрвөн бичиг”-ийн ухааныг баахан ч үл төсөөлөн бөгөөд цөлбөн бичсэн нь, /52/ хойч үед уншин төсөөлөгчид гарваас, барамын тоосны төдий, монголд тус болму хэмээсэн бөлгөө.

Ер миний мэдэж төсөөлсөн газар бяцхан ч үгүй, тийм боловч, багш нүгүүд битүү үгээр жолоодон сэнхрүүлэх, мянган утга, түмэн ухааны дотроос нэгэн ширхэг хагас мөхлөгийн төдий бараглан дагамжилсан миний энэхүү “дунд хэв”-ийн онолт нь чанараар эхлэн хоосноор төгссөн нь ил элэсоор удирласан болгон битүү эрдэмд хүрүүлэх арга шалтгаан мэт, богдын дүрмийг гадна илтгээд бурханы онолтыг дотроо агуулжээ. Инжаннаши би, ухааны хувьд багц төдий хүртэж төрсөн болбоос, урьд вангийн ёсыг сонсон төсөөлөх бөлгөө. /53/ Багш нөхөр Шоо Хү-гийн хэлсэн үг, бидний монголын шүтээн барилдлага ба шударгын буян нь хэдий зүйтэй мэт боловч, эдийн хишиг хийгээд ухааны хувь даан ч нимгэн, адагтаан ил гэгээн, тус гавьяат, соёлын ухаан үл төрөгдөх атал эчнээ нууц хоосон чанарт номын санваар хэрхэн дэлгэрсэн болов. Бидний энэ орны тэнгэрийн цаг мөс, гурван тохой дугуй хөлдмүй, газрын чадал цэцэг дөрвөн сард сая дэлгэрмүй, энэ нь бэлгийн амьсгал тавирчээ, уул болвоос орой үргэлжлэн, ус бөгөөс ёроол урвалхийлмуй, энэ нь шороон чадал мөхөсджээ. Тиймийн тул хүн нь зориг үгүй, амьтан нь өнгө үгүй, үүний дотор гол мөрөн үзүүр гарч далайд нэвтэрсэн, өвөр хэдэн хошууны /54/ хүн нь баахан мэдэлтэй шиг гэвч цолгорон нэвтэрч онцгой гарах нь машид цөөн. Олонх нь судар шинжвээс шарын шашны түйтгэр болмуй, бэхэс амталваас бичгийн хаалганы хулгай болмуй. Үүний дундаас гэнэт, өдрийн одон, шөнийн солонго мэт нэжгээд хошоод цолгорсон мэдэл ухаантан гарваас, од эсвээс эд чухаг, эсвээс эрх дутуу, эрхбиш нэгэн зүйлээр түүний хүчнийг бууруулж, цолгорон нэвтрэхэд хүрэх үгүй. Тиймийн тул манай Монголын бурхан ба богд гарахыг олонтоо олж сонсоогүй хэмээмүй. Аяа мөн болой, үнэн ажгуу. Үүгээр үзвээс, тэнгэр хүмүүнийг төрүүлэхүйд орон газрын чадал лугаа тэнцүүлэн хосолдуулан, барилдуулан төрүүлэхийг мэдвээс болох болой. /55/ Бурханы номонд үйлийн эрх хэмээмүй. Богдын бичигт тэнгэрийн төрөлх хэмээмүй. Түүний уг мөн чанарын онолт нь нэгэн адил, цөмөөр өнгө үгүй, үнэр үгүй, дуун үгүй, бод үгүй хоосон агаараар өөрийн хувьдаа ирж очихыг адилтган үлгэрлэн өгүүлсэн буюу. Тэнгэрийн төрүүлсэн хэмээгч Хурмаст тэнгэр түүнийг албадаж илгээснийг өгүүлсэн бус, бичгийн ёсонд илбэ ил гэрч, тодорхой тэмдэг үгүйг өгүүлэх үгүй тул, арга үгүй Хөх тэнгэр, гурван гэрэл, аянга, гилбэлгээнийг барьж, нийтээр итгэмжлүүлж, сайнд удирдах сэдлээр буюу. Богд Зы Си үйлийн эрхийг эс мэдсэн бус, бусдын эс мэдэхийг мэдэж тэнгэр хэмээсэн болой, Мэргэд бээр хянан шинжлэх ажаму. /56/